

# **ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

## **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль 1995 онд батлагдаж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа бөгөөд тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтын дагуу энэхүү үзэл баримтлалын төслийг боловсрууллаа.

### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.3.1-т “Иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, оролцоо, санаачилгыг дэмжих бодлогыг баримтлах бөгөөд төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ” гэж, 4.1.3.2-т “Улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд гурван талт болон олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ” гэж, 4.1.3.3-т “Нийгмийн зөвшилцөлд үндэслэн шийдвэр гаргах түвшинд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, санал авах, гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан бөгөөд мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д заасан Хангайн бүс, Баруун бүс, Хойд бүс, Төвийн бүс, Зүүн бүс Говийн бүсэд “Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ” гэж тусгажээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын тавд засаглалын бодлогын талаар заасан бөгөөд зорилго 5-д “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.” гэж зааснаас гадна “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5 дахь хэсэгт засаглалын талаар зааж, 5.2 дахь хэсэгт “Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.” гэж, 5.2.13-т “Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах, эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.” гэж, 5.2.14-т “Гэрээгээр гүйцэтгүүлж болох бүх

төрийн чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлэх тогтолцоог нэвтрүүлнэ.” гэж тус тус заасан.

## **1.2.Практик шаардлага**

Улс орны эдийн засгийн хөгжлийг дэмжих, худалдаа үйлдвэрлэлийн орчин үеийн тогтолцоо бий болгох, гишүүдийнхээ болон гадаад дотоодын худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим /цаашид “Үндэсний танхим” гэх/-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл, тогтолцоо, зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлсон Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль нь анх 1995 онд батлагдаж 2002, 2011, 2015 онуудад Иргэний хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай зэрэг хууль батлагдсантай холбоотойгоор 4 удаагийн нэмэлт, өөрчлөлтүүд орж байжээ.

Уг хууль нь Монгол Улсын хурдацтай өсөж буй бизнесийн орчинд Үндэсний танхим зохицон ажиллах, аж ахуй эрхлэгчдийн нийтлэх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллагад төлөөлөн илэрхийлэх, эдийн засаг, аж ахуйн зохистой орчин бүрдүүлэх үүднээс хууль тогтоомжийг боловсронгуй болгох зэрэг чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд багагүй хүндрэл учруулж байгаа, түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, тогтолцоо, гишүүнчлэл, санхүүжилт, танхимын зорилт, чиг үүрэг зэрэг нь орчин цагийн эдийн засаг, бизнесийн хөгжилтэй нийцэхгүй байгаа нь тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд харагдаж байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4-т “тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ шаардлага бий болсон” гэж санаачлагчийн зүгээс үзэж байна.

### **Тогтолцооны хувьд:**

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 5 дугаар зүйлээр танхимын тогтолцоог зохицуулсан бөгөөд мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэл, хот, эсхүл аймаг, хот дундын танхим байж болно” гэж заасан бөгөөд 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн, аймаг дундын танхимыг 50-иас доошгүй аж ахуйн нэгж, байгууллага Иргэний хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу үүсгэн байгуулж болно” гэж заасны дагуу бие даасан танхим байгуулах эрхийг аж ахуйн нэгж, байгууллагуудад нээлттэй болгох суурийг тавьжээ.

Энэхүү зохицуулалтаас үзвэл Монгол улс 1995 оноос эхлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэхийг зорьсон нь харагдаж байна. Тус зохицуулалтын дагуу 2015 онд “Улаанбаатар хотын худалдааны танхим”

ГҮТББ байгуулагдсан нь Үндэсний танхимаас гадна бие даан үйл ажиллагаа явуулж буй ганц танхим болж байна.

Түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 25 жилийн хугацаанд бие даасан танхим ганцхан нийслэлд байгуулагдсан байгаа нь тус хуулийн зохицуулалт нь шинэчлэгдэн батлагдаж буй бусад хуультай уялдаагүйгээс орон нутагт 50 аж ахуйн нэгж нэгдэж бие даасан танхим байгуулах боломж бага байна.

2021 оны байдлаар үйл ажиллагаа явуулж буй 56,8 мянган аж ахуйн нэгжийн 39,3 мянган аж ахуйн нэгж нь зөвхөн нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд орон нутагт санхүүжилтээ бие даан шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдээгүй... зэрэг шалтгааны улмаас худалдаа, аж үйлдвэрийн танхимыг бүс нутгийн зарчимд суурилж хөгжүүлэх зорилго биелээгүй байна.

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 10 дугаар зүйлээр Танхимын дүрмийг зохицуулсан байх бөгөөд уг зохицуулалтын дагуу Үндэсний танхимын зүгээс 1997 онд анхны салбар танхимыг байгуулж, өнөөдрийн байдлаар 21 аймагт салбар танхимтай үйл ажиллагаа явуулж байна. Тухайн салбар танхимууд нь салбарын гэрчилгээтэй, Үндэсний танхимаас оруулсан орлогын хувиар урамшуулал авдаг, зөвхөн гишүүнчлэлийн татвараа өөрсдийн орлого болгон зарцуулж байгаагаас үзвэл орон нутагт бие даасан танхим байгуулах зорилго нь Үндэсний танхимын салбар болсон байна.

Түүнчлэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн зөвлөмж хэсэгт цаашид бүс нутгийн зарчмаар бус, аж ахуйн нэгжүүдийн явуулж буй үйл ажиллагааны чиглэл, онцлог, салбар зэргийг харгалзан үзэж бизнесийн салбар тус бүрээр нэгдсэн мэргэжлийн худалдаа аж үйлдвэрийн танхим байгуулах замаар худалдаа, аж үйлдвэрийн танхимыг хөгжүүлэх, эдгээр танхимын төлөөлөл нь Үндэсний танхимын Их хурал, Удирдах зөвлөл зэрэг удирдах байгууллагыг бүрдүүлэх эь оновчтой талаар дурджээ.

Иймд худалдаа, аж үйлдвэрийн танхимыг дан ганц бүс нутгийн зарчимд суурилах бус, Үндэсний танхим нь орон нутгийн аж ахуй эрхлэгчдэд үйлчилгээгээ хүргэх зорилгоор салбар байгуулах тогтолцоог оновчтой тодорхойлох, шаардлагатай байна.

Мөн өнөөдрийн байдлаар “танхим” гэсэн нэр томъёоны тодорхойлолт давхцсан, худалдаа аж үйлдвэрийн танхимын зорилгыг илэрхийлэх үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо нийт 69 байгаагаас ТББ-ын хэлбэрээр 65 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан шаардлага хангасан бие даасан танхим нь 2015 онд байгуулагдсан “Улаанбаатар хотын худалдаа танхим” ГҮТББ байна.

Харин бусад ТББ хувьд “худалдааны танхим”, “танхим” болон “худалдаа, аж үйлдвэрийн танхим” зэрэг нэр томъёог ашигласан байгаа нь болохуйц нэр томъёог хэрэглэх нь төөрөгдөл үүсгэх, бизнесийн итгэлцэлд нөлөөлөх зэрэг сөрөг үр дагавар үүсгэх нөхцөл бүрдэж байх тул хуулиар хамгаалах, хуульд заасан шаардлага хангасан тохиолдолд ашиглах байдлаар хуульчлах шаардлагатай байна.

### **Чиг үүргийн хувьд:**

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулиар Үндэсний танхимд аж ахуй эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, төрийн эрх барих болон гүйцэтгэх байгууллагуудад төлөөлөх, хууль тогтоомжийн төсөлд санал өгөх зэрэг зорилгоо хэрэгжүүлэх асуудлыг хуульчилжээ.

Гэсэн хэдий ч он оны “Бизнес итгэлийн индекс” судалгаагаар эдийн засаг, бизнесийн талаар авч хэрэгжүүлж буй төр, засгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилт, үр дүнд сэтгэл хангалуун бус, бизнес итгэлийн ерөнхий индексийн өсөлт удаан, бизнесийн орчны шийдвэрлэвэл зохих асуудлууд нь “зээлийн хүү, бодлогын тогтворгүй байдал, авилга, хээл хахууль, татварын хувь хэмжээ, төрийн хүнд суртал, хариуцлагагүй, хууль хэрэгждэггүй байдал, төрийн нүсэр бүтэц” зэрэг тодорхой асуудлууд давтагдсаар байна.

Иймд тунхгийн шинжтэй, практикт хэрэгждэггүй, чиг үүргээ хангалттай сайн хэрэгжүүлэх хөшүүрэг байхгүй, аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төрийн байгууллагад хангалттай хэмжээнд төлөөлөн илэрхийлж чадахгүй байгаа зэрэг асуудлыг засах үүднээс нэмэгдүүлж, уялдуулах, ангилах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлох, төрийн байгууллагын дэргэдэх хамтын удирдлагын байгууллагуудад төлөөллөө оролцуулах, төрийн зарим чиг үүргийг эрх шилжүүлэн хэрэгжүүлэх боломжийг хуульд тусгах замаар бизнесийн орчныг дэмжих, итгэл үзүүлэх, хөгжих, эдийн засгийг тэлэх бодлогыг бодлогын түвшинд тодорхойлох шаардлага үүсэж байна.

Ингэснээр аж ахуй эрхлэгчдийн дуу хоолой шийдвэр гаргах түвшинд бодитоор хүрэх, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлснээр төрийн байгууллагын ачаалал буурах, төрд үүсэх зардал багасах, үйлчилгээний чанар сайжрах зэрэг олон давуу тал бий болохоор байна.

### **Санхүүжилтийн хувьд:**

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д танхимын санхүүжилт нь гишүүний татвар, иргэд байгууллагын хандив болон үйлчилгээний орлогоос бүрдэхээр заасан байна. Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн дүгнэлт, зөвлөмж хэсэгт 2015-2018 оны хооронд Үндэсний танхим нь нийт орлогынхоо 80-90 хувийг үндсэн үйл ажиллагааны

орлого болон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний үр дүнд олсон орлогоор бүрдүүлж байгаа бол 10-20 хувийг гишүүдийн хураамжаас бүрдүүлж байна. Мөн Үндэсний танхимын үндсэн үйл ажиллагааны орлого нь үйл ажиллагааны зардлаа нөхөж чаддаггүй, жил бүр алдагдалтай ажиллаж байгааг цаашид өөрчлөх, гишүүнчлэлийн тогтолцоог өөрчлөх замаар гишүүнчлэлийн хураамжийн Үндэсний танхимын орлогод эзлэх хувийг нэмэгдүүлэх зэргээр олон улсын жишигт нийцүүлэн санхүүжилтийн асуудлыг хуульд шинээр зохицуулах шаардлагатай байна. Тухайлбал, гишүүнчлэлийн хураамжийг тухайн мэргэжлийн танхим болон салбар танхимын үйл ажиллагааны нөхцөл байдал, орлогын хэмжээ зэрэгт тулгуурлан ялгамжтай байдлаар тогтоох, зарим танхимын гишүүдийг хураамжаас чөлөөлөх эрхийг тухайн мэргэжлийн танхим болон салбар танхимд олгох зэргээр олон улсын туршлагаас өөрийн орны онцлогт тохируулан сайжруулах шаардлага зүй ёсоор бий болжээ.

Санхүүжилтийн асуудлыг шинээр зохицуулснаар Үндэсний танхим төдийгүй мэргэжлийн танхим, салбар танхим нь хуульд заасан бүрэн эрх, чиг үүргээ санхүүгийн хувьд хүндрэл бэрхшээлгүй хэрэгжүүлэх боломж нээгдэх бөгөөд тодорхой хэмжээний төсвийг бизнесийн орчны суурь судалгаа хийх, бие даасан судалгааны институт байгуулах, өөрийн гэсэн бизнесийн орчны мэдээллийн нэгдсэн сантай болох, холбогдох хуулийн төсөлд санал өгөхдөө тусгайлан судалгаа хийлгэж илүү бодитой, аж ахуй эрхлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалах зэргээр чиг үүргээ бодитой хэрэгжүүлэх нэг хөшүүрэг болох юм.

Мөн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т “Танхимын үйлчилгээний хөлсний хэмжээг танхимын саналыг үндэслэн Сангийн сайд, Худалдаа үйлдвэрийн сайд хамтран тогтооно” гэж заасан байгаа нь тухайн байгууллагын орлогын гол эх үүсвэрээ бүрдүүлж буй үйл ажиллагаанд төрийн зүгээс оролцож болох зохицуулалт юм. Зах зээл, эдийн засгийн өөрчлөлтөөс хамааран үйлчилгээний хөлс өөрчлөгдөх, шинэ үйлчилгээ бий болсноор түүний үнийг тогтоох, зарим бизнесийг дэмжих зорилгоор үнэ, хөлсийг бууруулах, эсхүл чөлөөлөх арга хэмжээ авах шаардлагатай байдаг боловч тохиолдолд бүрд Сангийн сайд болон Худалдаа үйлдвэрийн сайдын хамтарсан шийдвэр гарахыг хүлээх нь танхимын бие даасан, хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх юм. Гадаад улсад үйлчилгээний хөлсийг худалдаа, аж үйлдвэрийн танхимын Их хурал, эсхүл Удирдах зөвлөл тогтоох зохицуулалттай бөгөөд худалдаа, аж үйлдвэрийн танхимын зүгээс тодорхой хэмжээний шат дамжлага, хяналт тогтоосон байна. Иймд Үндэсний танхимын хувьд гадаадын зарим улсын туршлагаар үйлчилгээний хөлсийг танхим өөрөө тогтоох болон түүний хяналтын тогтолцоог бий болгох зэрэг өөрчлөлт хийх шаардлагатай байна.

## **Үндэсний танхимын зарим үйлчилгээний хувьд:**

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 8 дугаар зүйлд Төрийн болон төрийн бус байгууллага дахь эвлэрүүлэн зуучлагчийн талаарх харилцааг зохицуулсан бөгөөд 8.1-д “Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно” гэж заасан бөгөөд Үндэсний танхимын дэргэд анх 2014 онд эвлэрүүлэн зуучлах төв байгуулагдаж, тухайн үедээ эвлэрүүлэн зуучлалын албаны дарга, нарийн бичиг, 18 эвлэрүүлэн зуучлагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байжээ. Гэвч Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч биелүүлээгүй бол нөгөө тал нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1-д заасны дагуу шүүхэд хандах эрхтэй” гэж заасан нь тухайн эвлэрүүлэн зуучлагчийн шийдвэрийг шүүгч баталгаажуулж, захирамж гаргадгүйгээс заавал биелэгдэх шинжгүй болсон байна. Иймд Үндэсний танхимын дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалын төвийн шийдвэрийг Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасны нэгэн адил шүүгч баталгаажуулж, захирамж гарган шүүхийн шийдвэрийн нэгэн адил заавал биелэгддэг болох боломжийг хуульд тусгах шаардлагатай байна.

Иймд дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн Үндэсний танхимын тогтолцоог эдийн засаг, бизнесийн орчин төдийгүй нутаг дэвсгэр, хүн ам зүйн тархалт зэргийг харгалзан үйл ажиллагаа явуулж буй нийт аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бүтцийг бий болгох, аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд Үндэсний танхимын хэрэгжүүлж болох чиг үүргийг нэмэгдүүлэх, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх боломжийг нээх, үйл ажиллагаагаа бие даасан, хараат бусаар хэрэгжүүлж чадахуйц санхүүгийн чадамжтай болгох зэргээр үйл ажиллагааг нь боловсронгуй болгох нөхцөл бий болсон.

## **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хууль тогтоомжийн тухай 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасныг үндэслэн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгох, шинээр бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмэх, өөрчлөлт оруулахад хуулийн нийт заалтын тавиас дээш хувь нь хөндөгдөж байгаа тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь 8 бүлэгтэй байх бөгөөд дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан зохицуулах харилцаа, хамрах хүрээг дараах байдлаар тусгана. Үүнд:

**Нэгдүгээр бүлэгт:** Хуулийн зорилт, худалдаа, аж үйлдвэрийн танхимын хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, худалдаа, аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагаанд баримтлах зарчмыг;

**Хоёрдугаар бүлэгт:** Худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилго, зохион байгуулалт, гишүүнчлэл, танхимын нэрийг;

**Гуравдугаар бүлэгт:** Салбар танхимын зохион байгуулалт, санхүүжилтийг;

**Дөрөвдүгээр бүлэгт:** Мэргэжлийн танхимын зохион байгуулалт, санхүүжилтийг;

**Тавдугаарт бүлэгт:** Үндэсний танхимын чиг үүрэг, зохион байгуулалт, санхүүжилтийг;

**Зургаадугаар бүлэгт:** Худалдаа, аж үйлдвэрийн танхимаас бусад этгээдтэй харилцах харилцаа, төрийн байгууллага, албан тушаалтан болон бусад этгээдтэй харилцах харилцаа, Үндэсний танхим болон мэргэжлийн танхим, салбар танхим хоорондын харилцах журмыг;

**Долоодугаар бүлэгт:** Үндэсний танхимын үзүүлэх зарим үйлчилгээ болох гарал үүслийн гэрчилгээ олгох, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдлын гэрчилгээ олгох, бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулах баримт бичиг олгох, хөндлөнгийн экспертизийн үйлчилгээ, орон нутагт үйлдвэрлэсэн бараа, материал үйлчилгээний тодорхойлолт олгох үйлчилгээ үзүүлэх нөхцөл, журам, арбитрын үйлчилгээ, эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ болон оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээг;

**Наймдугаар бүлэгт:** Худалдаа, аж үйлдвэрийн танхимын хараат бус байдал, үйл ажиллагааны тайлан болон хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгана.

**Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар:

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын бүтэц, зохион байгуулалт, түүний бүрэн эрх тодорхой болсноор аж ахуй эрхлэгчид эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах, хамтын удирдлагын байгууллагаар дамжуулан дуу хоолойгоо төр болон олон нийтэд хүргэх боломж бололцоо нэмэгдэнэ.

Монгол Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхимын тогтолцоо нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг нэг танхим болон эдийн засгийн үйл ажиллагааны салбараар дагнан байгуулагдсан мэргэжлийн танхим болон аймаг, нийслэлд байгуулагдах салбар танхимуудаас бүрдэх тул тодорхой бизнес, эдийн

засгийн салбарын аж ахуй эрхлэгчид нь тус бүрийн салбарын асуудлаа мэргэжлийн танхим дээрээ хэлэлцэн ярилцах, орон нутаг, нийслэлийн аж ахуй эрхлэгчид салбар танхим дээрээ хэлэлцэн, ярилцсаны үндсэн дээр нэг шийдэл, шийдвэрт хүрэх боломжтой болох юм.

Хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд “үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим”, “худалдаа, аж үйлдвэрийн танхим” болон худалдаа, аж үйлдвэрийн танхимын зорилгыг илэрхийлэх нэр томъёог хэрэглэх боломжтой болж нэрийн хамгаалалт бий болно.

Үндэсний танхимын гишүүнчлэлийг шинээр зохион байгуулснаар тухайн байгууллагаас үйлчилгээ авах аж ахуй эрхлэгчдийн тоо нэмэгдэж, цаг хугацаа, эдийн засгийн хувьд хэмнэлттэй болно.

Үндэсний танхим болон мэргэжлийн танхим, салбар танхим нь үйл ажиллагаагаа хараат бус, бие даасан байдлаар явуулах санхүүгийн боломж бий болно. Ингэснээр аж ахуй эрхлэгчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлд ахиц гарах болно.

Аж ахуй эрхлэгчдийн хооронд үүссэн маргааныг заавал шүүхээр шийдүүлэх бус эвлэрүүлэн зуучлагчийн тусламжтай шийдүүлж, тухайн шийдвэр нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил биелэгдэнэ. Үүнтэй холбоотойгоор бизнесийн эрх зүйн холбогдолтой маргааныг дагнан шийдвэрлэх, мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчид бий болох боломжтой юм. Дээрх нөхцөлүүд бүрдсэнээр шүүх дэх иргэний хэрэг маргааны ачаалал буурах эерэг талтай байна.

Үндэсний танхимын чиг үүрэг тодорхой болж, холбогдох төрийн байгууллагаас зөвшилцсөний үндсэн дээр зөвлөл, хороо, комисс зэрэг хамтын удирдлагын бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулах боломж бий болно.

Худалдаа, аж үйлдвэрийн танхим үйл ажиллагаагаа улс төрийн нам, эвслийн үйл ажиллагаанаас ангид явуулах зэрэг боломж бий болно.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хуулиудтай нийцүүлэн боловсруулагдах бөгөөд худалдаа, аж үйлдвэрийн танхимын чиг үүргийг тодорхой болгох зорилгоор 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдөр баталсан Худалдаа, аж үйлдвэрийн танхим хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---